

## Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны нэгдүгээр сарын байдлаар)

### I.Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2016 оны 1-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 83.2 хувьтай буюу 242.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 18.0 хувьтай буюу 31.8 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 274.7 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 58.6 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 2806.0 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 95.6 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 700.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 1863.0 сая төгрөг, нийт 2563.0 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Баянжаргалан, Өндөршил, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумд 3.5-32.1 хувиар буюу 183.0-1712.0 мянган төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн бол бусад бүх сумд төлөвлөгөөгөө 2.0-77.5 хувиар тасалдуулсан байна.

### II.Төсвийн зарлага



2016 оны эхний 1 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 491.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 69.0 хувиар буурсан байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 165.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 86.9 хувиар буурч нийт зардлын 33.6 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 85.1 хувиар буурч 17.5 сая төгрөг болсон байна. Тухайн сарын байдлаар эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бусад урсгал шилжүүлгийн зардлууд өссөн бол бусад бүх зардлууд өмнөх оны мөн үеэс 24.0-87.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### III.Банк



Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өсч 77622.4 сая төгрөг болов. Үүнээс хугацаа хэтэрсэн зээл 488.6 сая төгрөг, чанаргүй зээл 325.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс 2-3 дахин өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1.0 хувийг хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өсч 25857.0 сая төгрөг болов.

### IV.Бүртгэлтэй ажилгүй иргэн



2016 оны 1 сарын байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа 793 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 165 хүнээр өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 48.5 хувь буюу 385 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 266 ажилгүйчүүд ногдож байхад Гурвансайхан /513/, Баянжаргалан /443/, Говь-Угтаал /359/, Эрдэнэдалай /325/ байгаа нь аймгийн дундачаас дээгүүр байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.1 хувь магистр, 19.9 хувь нь дипломын болон баклавын дээд, 6.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 11.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 33.9 хувь нь бүрэн дунд, 18.7 хувь нь суурь, 7.6 хувь нь бага, 2.6 хувь нь боловсролгүй иргэд байна.

### V.Ажлын байрны зуучлал



Хөдөлмөрийн хэлтсийн 2016 оны эхний 1 сарын мэдээгээр нийт 8 хүн ажлын байранд зуучлагдан орсон байна. Ажлын байранд зуучлагдан ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 12.5 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбар, 12.5 хувь нь ХАА ан агнуур ойн аж ахуй, 12.5 хувь нь боловсрол, 12.5 хувь нь бөөний ба жижиглэн худалдаа, 12.5 хувь нь мэдээлэл холбоо, 12.5 хувь нь мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, 25 хувь нь бусад салбарт ногдож байна.

## VI. Í eéā eéí āāàōāē



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны нэгдүгээр сарын байдлаар 2257,7 сая төгрөг, зарлага 1789,9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 211.7 сая төгрөг буюу 45,9 хувь, зарлага 186.3 сая төгрөг буюу 21,3 хувиар өслөө.

Аeí æeí í eéā eéí āāàōāēūí øyèøñeéí ì ýāýāýūð í eéā eéí āāàōāēēā энэ 1 р сард 2541 õĵí ø èì òāýè ò° è° ā-, āāàōāóēāā-āāð áĵðòāýāāñýí eé 849 õĵí áóþ ó 33,4 óóāü í ü àæ àðóeí í ýāæ, āāeāóeēāāāāñ, 1436 õĵí áóþ ó 56,5 óóāü í ü ò° ñ° āð āāeāóeēāāāāñ, 256 õĵí áóþ ó 10,1 óóāü í ü ñāeí āóðāāð ø èì òāýè ò° èñ° í āāeġāā нь өмнөх оноос өссөн байна.

Í eéā eéí āāàōāēūí ñāí āāāñ î eā ñí í øyòāýāðeéí øyì æýý энэ сарын байдлаар 1646,9 ñāý ò° ā áí eā ĵĵí eé 81,5 óóāeēā ° í ā° ð í āñí ü, 12,8 óóāeēā ° õ æeēeéí áýððø ýýèòýé eðāýāeéí, 2,9 óóāeēā øýæýā-ýý āeāñāí ü, 2,8 óóāeēā øýðæeí øyòāýāýð ýçýèæ āāeí ā.

Энэ сард øyòāýāðeéí āāàōāēūí ñāí āāāñ øyòāýāýð āāāā-6315 õĵí āāeí ā. Í eéò øyòāýāýð āāāā-āüí 79,8 óóāü áóþ ó 5046 хүн ° í ā° ð í āñí ü, 14,9 óóāü áóþ ó 938 õĵí òāðeð āóóóāeéí, 3,6 óóāü áóþ ó 225 õĵí øýæýā-ýý āeāñāí ü, 1.7 óóāü áóþ ó 106 õĵí í ü øýðæeí øyòāýāýð āāāā-eā āāeí ā.

Í ° í энэ сард øyòāýā æeéí āāàōāēūí ñāí āāāñ øyòāýā æ āāāā-eā 142 - Í Ø° -í eé āāàōāēūí ñāí āāāñ øyòāýāýð, øyòāýā æ āāāā-eā 14 ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагчид 15 хүн байна.

Ýíý 1 сарын байдлаар ýðĵĵë ì ýí āeéí āāàōāēēā āāàōāóēāā-ēeéí òí í 11155 āāeāāāæeéí 96,5 óóāü áóþ ó 10761 ò° ð òāðeòóāð eðāýā, 1,5 óóāü áóþ ó 164 māe-ēā, 2,1 óóāü áóþ ó 230 î þ óóāí ñóðāeòāāñāā, āæ àðóeí í ýāæeéí ýçýí, óóāeāðāā ò° ā° èì ° ð ýððeýā- eðāýí āāeí ā.

2016 оны 1 сарын байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр í eéā eéí āāàōāēūí ø èì òāýèeéí î ðeí ā 664,3 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 6,2 óóāeāð буюу 38,8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн āāeí ā. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө Дэлгэрцогт, Дэрэн, Говь-Угтаал, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Луус, Сайхан-

Овоо, Эрдэнэдалай сумаас бусад сумд 1,3-69,7 хувиар буюу 0,2-11,5 сая төгрөгөөр тасалсан байна.

## VII. Эдĵĵë ì ýí ā



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд энэ оны 1 р сарын байдлаар 83 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 2 төрөлтөөр өссөн ба нийт төрсөн эхчүүдийн 82,8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ оны байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

2016 оны эхний 1 сарын байдлаар нялхсын эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдсэн нь Өлзийт мандал эмнэлэгт өвчний улмаас 1 хүүхэдд эндсэн байна. Мөн 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн Дэлгэрхангай суманд өвчний улмаас 1 хүүхэд эндсэн байна.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр нас баралтын 26 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 2 тохиолдлоор нэмэгджээ. Нас барсан хүний 7,7 хувь буюу 2 хүн эмнэлэгт нас барсан байна. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр 19,2 хувийг эзэлж байна. Мөн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдол 2 гарч, нийт нас баралтын 7,7 хувийг эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг бүтцээр нь авч үзвэл амиа хорлосон 1, бусдад хорлогдсон 1 байна.

2016 оны байдлаар стационарит шинээр 908 эмчлүүлэгч хэвтэж 850 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 6737 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7,9 байна.

Энэ 1 сарын байдлаар 11543 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 19,5%, амбулаторийн үзлэг 53,2 %, идэвхитэй хяналт 17,5 %, гэрийн үзлэг 9,8 %- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35,2 хувь нь эрэгтэй, 64,8 хувь нь эмэгтэй хүн байна.

2016 оны 1 сарын байдлаар хорт хавдрын 4 өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдэж, хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсээс 9 хүн нас барсан байна.

Аймгийн хэмжээнд энэ оны эхний 1 сарын байдлаар халдварт өвчний 39 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 7 тохиолдлоор өсч, 10000 хүн амд ногдох халдварт

өвчнөөр өвчлөгчдийн тоо 7,7 болж өмнөх оны мөн үеэс өссөн байна.

Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчний тохиолдол буурсан боловч, салхинцэцэг, улаан бурхан өвчний тохиолдлууд нэмэгджээ. Халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл бэлгийн замын халдвар 33,3 хувь, амьсгалын замын халдвар 64,1 хувь, бусад өвчлөл 2,6 хувийг тус тус эзэлж байна.

### VIII. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2016 оны 1-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2015 оны 1-сартай харьцуулахад харьцуулахад 4,8 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 4,8 хувиар өсөхөд хувцас бөс бараа гутлын бүлэг 7.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 21.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 6,0 хувь, боловсролын бүлэг 32.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур, байрны үйлчилгээний бүлэг 15,0 хувь бусад бараа үйлчилгээ 3,3 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Тухайн сарын үнийг өмнөх сарын үнийн мэдээтэй харьцуулахад 1,0 хувиар өссөн байна.

2016 оны 1 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлш болон ноолуурын үнийг орууллаа.

№	Барааны нэр, төрөл	XII/30	I/6	I/13	I/20	I/27
1	Гурил, I зэрэг, кг	1250	1250	1250	1350	1250
2	Хонины мах, кг	3500	3700	4500	4500	4700
3	Үхрийн мах, кг	0	0	0	0	0
4	Ямааны ястай мах	3000	3000	3500	4000	4000
5	Элсэн чихэр, кг	1650	1650	1650	1700	1650
6	Цагаан будаа, кг	2200	2230	2230	2250	2230
7	Шингэн сүү, л	2500	2500	2500	2500	2500

8	Ноолуурын үнэ 1кг:- Цагаан	53000	53000	53000	53000	53000
	- Бор	53000	53000	53000	53000	53000
	- Холимог	53000	53000	53000	53000	53000
9	Бензин, А-80, 1 литр	1550	1550	1550	1550	1500
10	Бензин, А-92, 1 литр	1800	1800	1800	1800	1680
11	Дизелийн түлш, 1 литр	1880	1880	1880	1880	1760

### IX. Хөдөө аж ахуй



Аймгийн хэмжээнд энэ оны 2 сарын 1 ны байдлаар 6874 толгой мал хорогдоод байна. Үүний 67,1 хувь нь ямаа, 25.0 хувь нь хонь, 7,9 хувийг бод малын хорогдол эзэлж байна. Нийт хорогдсон том малын 8,4 хувь нь хээлтэгч мал байна.

### X. Аж үйлдвэр.



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2016 оны 1 сарын байдлаар 552.4 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12.9 хувиар өссөн байна.

### XI. Гэмт хэрэг



Цагдаагийн хэлтсийн 2016 оны эхний 1 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 18 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 53,8 хувиар буюу 21 хүнээр буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогсдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21,7 хувиар буурч 18 хүн холбогдоод байна. 2016 оны эхний 1 сарын байдлаар хүчин, дээрэм, булаалт, танхай, ашиглал, малын хулгай, албан тушаал, гал түймэрийн гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс бусдын өмчийн хулгай 81,2 хувиар буурсан ба бусдын бие мах бодод учруулсан болон залилангийн хэрэг мөн үеийн түвшинд харин бусад хэргүүд буурсан үзүүлэлттэй байна. Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 44,4 хувийг бусдын бие махбодьд гэмтэл учруулсан, 16,7 хувийг хулгайн, 5,6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, 11,1 хувийг залилан, 5,6 хувийг хүн амь, 11,1 хувийг золгүй учрал, 5,5 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 38,9 хувийг согтуугаар үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 6 хүн байхад Дэлгэрцогт 9, Хулд 13, Сайнцагаан 14, Гурвансайхан 7 хүн байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 10,5 сая төгрөг, түүний 74,3 хувь буюу 7,8 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна.



## **XII Байгаль орчин**

**Дундговь аймгийн нутгаар 2016 оны 2 р сард цаг агаар ямар байх тухай урьдчилсан төлөв**

### **ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ**

Энэ сарын агаарын дундаж температур нь нутгийн зүүн хойнд хэсгээр 15-20 градус, бусад сумдаар 8-13 градус хүйтэн буюу нийт нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Нэг ба гуравдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч чангарч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 22-27 градус, өдөртөө 10-15 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 17-22 градус, өдөртөө 6-11 градус хүйтэн байна. Харин хоёрдугаар арав хоногийн эхний хагаст болон гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст хүйтний эрч суларч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 13-18 градус, өдөртөө 1-6 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 9-14 градус хүйтэн, өдөртөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан байна. Бусад хугацаанд нийт нутгаар шөнөдөө 16-21 градус, өдөртөө 5-10 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 12-17 градус, өдөртөө 1-6 градус хүйтэн байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь нутгийн зүүн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй.

Нэг ба гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр нутгийн хойд хэсгээр бага зэргийн цас орно. Хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар цас орно.

Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн сүүлийн хагаст зарим газраар 16-18м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.

## **Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөх тухай**

2 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын температур нийт нутгаар олон жилийн дунджийн орчим, хур тунадасны хувьд нутгийн зүүн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу бусад нутгаар дунджийн орчим орохоор байна.

Цаашид цас их орж, цасны зузаан улам нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлөхөөр байна. Мөн үе үе хүчтэй цасан шуурга шуурч, малын хариулга маллагаа болон зам тээврийн ажилд хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.

### **2016 оны 3 дугаар сарын цаг агаарын төлөв**

Энэ сарын агаарын температурын дундаж нь нийт нутгаар 5-10 градус хүйтэн буюу нутгийн хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас 1.0 градусаар дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь нутгийн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй.